



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 2/101

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн хүнсний агуулах барих ӨВАХУСЗДТГ/202307032" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Жамъянсүрэн (Ерөнхий боловсролын сургуулийн менежер)

Гишүүд: Д.Мягмарсүрэн (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Зууннаст (Иргэний төлөөлөл - зөвшилцсөнөөр)

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Жамъянсүрэн)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ

622371323

D:Alban bichig;Zahiramj 2023